

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ
ТӨҮГ-ЫН ДАРГА Э.ТЭГШЖАРГАЛ
ТАНАА

2020. 03. 13 № 06/860
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, зорилтот түвшин, гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Аудитаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын авлагын үлдэгдэлд байгаа 2010 оноос хойш төлөгдөөгүй 341 харилцагчийн 397.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуагүй, ерөнхий удирдлагын зардлыг 52.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Э.Тэгшжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн дансны авлагын үлдэгдэлд тооцоо нийлэх, найдваргүй авлагын нөөц байгуулах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 03 дугаар сарын 09–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Эвиденсе аудит ХХК-ийн аудитор С.Бадамгарав, Ж.Амаржаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгын хамт Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 97 дугаар албан тоотой ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь үйл ажиллагааны зорилгоо “Монгол Улсын эрдсийн шинжилгээний үнэн зөв, баталгаатай үр дүнгээр захиалагч, үйлчлүүлэгчдийг хангах” гэж тодорхойлсон.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрдсийн түүхий эдийн тоон ба хагас тоон шинжилгээ;
- Бодисын найрлагын судалгаа;
- Ашигт малтмалын баяжигдах шинж чанарын лаборатори технологийн туршилт;
- Хүдрийн бус ашигт малтмалын физик механикийн шинж чанарын судалгаа;
- Нүүрсний шинжилгээ;
- Байгаль орчны судалгаа, шинжилгээ (цианид, мөнгөн ус, хүнд металл);
- Ур чадварын сорилт зохион байгуулагч;
- Стандартчилсан загвар, аттестатчилсан стандартчилсан загварын үйлдвэрлэл;
- Лаборатори хоорондын гадаад хяналт, экспертиз шинжилгээ;
- Чулуун бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэрлэл зэрэг болно.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хувьд өөрчлөлт орсныг мөрдөн ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомж, өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж, ажиллаагүй байна.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Даймонд ” программ хангамж ашигладаг байна.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон 3,873.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 38.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тооцсон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнгээс 1.0 хувиар тооцож 45.9 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93.7 сая төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	561.4	716.5	155.1
Авлага	1,306.4	1,010.1	-296.3
Бараа материал	1,229.2	1,173.0	-56.2
Урьдчилж төлсөн зардал	17.8	32.0	14.2
Үндсэн хөрөнгө	10,275.3	10,552.2	276.9
Нийт хөрөнгө	13,390.1	13,483.8	93.7
Өр төлбөр	954.7	1,276.2	321.5
Эздийн өмч	12,435.4	12,207.6	-227.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	13,390.1	13,483.8	93.7

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 155,1 сая төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон орсон орлого нэмэгдсэнтэй холбоотой

Авлага дансны бууралт нь өмнөх оны авлага барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2010 оноос хойш хөдлөөгүй 273 байгууллага, 68 хувь хүмүүсийн 397.3 сая төгрөгийн шинжилгээний ажлын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь урвалж бодис, материалын зарцуулалт өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 276.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Мон лаа ХХК-ийн 151.1 сая төгрөгийн авлагаа барагдуулж Nissan patrol маркийн автомашин орлогод авсан, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 193.3 сая төгрөгийн хөрөнгө орлогод авч дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 572 тоот тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн 20.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 321.5 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд Мед импексээс худалдан авсан шинжилгээний тоног төхөөрөмжийн үлдэгдэл 180.0 сая төгрөгийн төлбөр, шинжилгээний ажлын урьдчилж орсон 229.3 сая төгрөгийн орлогоос шалтгаалсан байна.

Эздийн өмч нь тайлант хугацаанд алдагдалтай ажилласантай холбоотойгоор 227.8 сая төгрөгөөр буурчээ.

2.9. Зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан 2019 онд зорилтот түвшингийн төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагааны шинжилгээний орлого 3,545.2 сая төгрөг, чулуун бүтээгдэхүүний орлого 80.0 сая төгрөг, стандарт загварын орлого 60.0 сая төгрөг, бусад орлого 20.0 сая төгрөг нийт 3,705.2 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр, шинжилгээний орлого 3,874.2 сая төгрөг, чулуун бүтээгдэхүүний орлого 110.5 сая төгрөг, стандарт загварын орлого 199.3 сая төгрөг, бусад орлого 46.4 сая төгрөг нийт 4,230.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 525.2 сая төгрөг буюу 14 хувиар давуулан биелүүлжээ.

Зорилтот түвшинд 2019 оны нийт үйл ажиллагааны зардалд 3,575.5 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,596.2 сая төгрөг буюу 28.5 хувиар зардлыг хэтрүүлж 366.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Алдагдалтай ажилласан шалтгаан нь тоног төхөөрөмж хуучирсантай холбоотойгоор засвар, үйлчилгээний зардлууд хэтэрсэн ба урвалж материал бодисыг гаднаас худалдан авдагтай холбоотой валютын ханшийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл тодорхойлоогүй бөгөөд нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 449.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 397.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, ерөнхий удирдлагын зардал хэтрүүлсэн 52.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

Аудитаар илэрсэн 397.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дуусаагүй үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүн дансанд хуваарилах зардлын ангиллыг зөв бүртгэсэн эсэхийг авч үзэхээр шийдвэрлэв.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Геологийн төв лаборатори ТӨҮГазар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зорилтот түвшин, гүйцэтгэлийн 36, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 29, бусад 50 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2018 оны жилийн эцсээр 341 харилцагчийн 397.3 сая төгрөгийн авлага байсан нь тайланд онд барагдаагүй, өмнөх жилийн үлдэгдлээс өөрчлөгдөөгүй тооцоо нийлсэн акт бичиг баримт байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Авлага, өр төлбөрийг барагдуулж ажиллаагүй байх, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх, холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Авлагын эцсийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг дахин давтахгүй анхаарч ажиллана.

3.2 Зардалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Дансны авлагын үлдэгдэл ихтэй бөгөөд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй, авлагыг цэвэр боломжит дүнгээр нь тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн.

3.2.2 Эрсдэл: Зардал дутуу илэрхийлэгдэх, тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Дансны авлагад найдваргүй авлагын нөөц байгуулж, авлагыг цэвэр боломжит дүнгээр тусгах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж, цаашид нөөц байгуулан анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	/төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	561,376,931.37	716,460,163.03
1.1.2	Дансны авлага	1,306,439,851.24	1,009,648,189.55
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	421,788.13
1.1.6	Бараа материал	1,229,247,033.90	1,172,971,108.84
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	17,762,800.00	32,088,961.19
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,114,826,616.51	2,931,590,210.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,141,281,862.98	10,394,889,268.23
1.2.2	Биет бус хөрөнгө	133,992,641.68	157,318,772.05
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,275,274,504.66	10,552,208,040.28
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,390,101,121.17	13,483,798,251.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	201,824,756.66	493,492,338.10
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	242,638,908.22	37,943,325.62
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,228,141.07	5,133,288.01
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	508,458,390.43	737,724,664.44
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	590,295.80	1,900,556.28
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	954,740,492.18	1,276,194,172.45
2.2	Өр төлбөрийн нийт дүн	954,740,492.18	1,276,194,172.45
2.3.1	Төрийн өмч	3,413,613,163.67	3,413,613,163.67
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	1,163,443,000.00	1,356,775,300.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,985,275,518.69	5,985,275,518.69
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	978,235,676.75	978,235,676.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	894,793,269.88	473,704,419.46
2.3.11	Эздийн өмчийн дүн	12,435,360,628.99	12,207,604,078.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	13,390,101,121.17	13,483,798,251.02

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,269,344,271.28	4,217,197,141.85
2	Борлуулалтын өртөг	3,483,489,953.18	4,135,275,410.90
3	Нийт ашиг (алдагдал)	785,854,318.10	81,921,730.95
5	Хүүгийн орлого	2,449,898.51	11,023,178.63
8	Бусад орлого	0.00	454,545.45
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	260,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	338,713,979.19	381,592,110.25
12	Бусад зардал	35,735,953.33	78,989,569.42
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,537,804.36	1,710,702.91
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-15,053,540.17	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	403,338,548.28	-365,731,521.73
19	Орлогын татварын зардал	43,391,276.08	1,102,317.86
20	Татварын дараах ашиг (алдагдал)	359,947,272.20	-366,833,839.59
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	359,947,272.20	-366,833,839.59
24	Орлогын нийт дүн	359,947,272.20	-366,833,839.59
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,859,990,605.83	5,205,961,524.19
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	4,610,781,822.97	5,196,541,277.64
1.1.4	Буцаан авсан албан татвар		2,923,295.27
1.1.6	Бусад мөнгөн орлого	249,208,782.86	6,496,951.28
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,156,611,654.67	5,009,470,040.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,529,582,325.00	1,725,472,158.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	478,691,116.23	569,773,723.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	713,129,861.64	1,805,821,759.99
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	181,121,771.08	214,666,372.20
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	147,864,348.24	113,000,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	912,395,789.68	488,035,353.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,278,702.72	8,096,028.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	185,547,740.08	84,604,645.56
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	703,378,951.16	196,491,483.96
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,848,898.51	11,023,178.63
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	7,399,000.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,449,898.51	11,023,178.63
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	188,809,874.42	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	188,809,874.42	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-178,960,975.91	11,023,178.63
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,883,845.85	6,586,056.76
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	6,883,845.85	6,586,056.76
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	30,260,141.49	59,017,487.69
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		702,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	27,914,100.00	54,255,010.83
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	2,346,041.49	4,060,476.86
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-23,376,295.64	-52,431,430.93
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	501,041,679.61	155,083,231.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,335,251.76	561,376,931.37
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	561,376,931.37	716,460,163.03

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,413,613,163.67	0.00	773,675,947.28	878,158,426.75	587,672,978.28	5,653,120,515.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	-24,912,880.60	-24,912,880.60
Залруулсан үлдэгдэл	3,413,613,163.67	0.00	773,675,947.28	878,158,426.75	562,760,097.68	5,628,207,635.38
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гаргасан өөрчлөлт		1,163,443,000.00	0.00	0.00	0.00	1,163,443,000.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	-27,914,100.00	-27,914,100.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	359,947,272.20	359,947,272.20
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	5,211,599,571.41	100,077,250.00	0.00	5,311,676,821.41
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,413,613,163.67	1,163,443,000.00	5,985,275,518.69	978,235,676.75	894,793,269.88	12,435,360,628.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	3,413,613,163.67	1,163,443,000.00	5,985,275,518.69	978,235,676.75	894,793,269.88	12,435,360,628.99
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00		0.00	0.00
Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	193,332,300.00	0.00	0.00	0.00	193,332,300.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	-54,255,010.83	-54,255,010.83
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	-366,833,839.59	-366,833,839.59
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,413,613,163.67	1,356,775,300.00	5,985,275,518.69	978,235,676.75	473,704,419.46	12,207,604,078.57

4.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл

/төгрөг/

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Зөрүү
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	3,685,215,500.0	4,184,069,703.8	113.5	498,854,203.8
	а) Гол нэр төрлөөр: - Шинжилгээний ажил	3,545,215,500.0	3,874,244,939.9	109.3	329,029,439.9
	- Чулуун бүтээгдэхүүн борлуулалт	80,000,000.0	110,541,800.3	138.2	30,541,800.3
	- Стандарт загварын борлуулалт	60,000,000.0	199,282,963.6	332.1	139,282,963.6
	- Бусад орлого	20,000,000.0	46,355,634.6	231.8	26,355,634.6
	б) Үнийн дүнгээр	3,705,215,500.0	4,230,425,338.4	114.2	525,209,838.4
2	Нийт орлого	3,705,215,500.0	4,230,425,338.4	114.2	525,209,838.4
	Үүнээс: Цэвэр борлуулалт	3,545,215,500.0	3,874,244,939.9	109.3	329,029,439.9
3	Нийт зардал	3,575,518,000.0	4,596,156,760.1	128.5	1,020,638,760.1
	Үүнээс: Удирдлагын зардал	329,138,200.0	381,592,110.3	115.9	52,453,910.3
	Үндсэн ба нэмэгдэл цалин	275,976,300.0	275,541,398.0	99.8	-434,902.0
	НДШ	30,909,300.0	39,608,989.0	128.1	8,699,689.0
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	2,000,000.0	17,775,997.5	888.8	15,775,997.5
	Ашиглалтын зардал	5,000,000.0	13,299,578.8	266.0	8,299,578.8
	Унааны зардал	2,000,000.0	2,594,818.2	129.7	594,818.2
	Шуудан, холбоо	2,000,000.0	2,169,581.3	108.5	169,581.3
	Бичиг хэргийн зардал	3,000,000.0	3,278,591.9	109.3	278,591.9
	Санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн аудит хийсэн зардал	3,000,000.0	3,000,000.0	100.0	0.0
	Бусад зардал	5,252,600.0	24,323,155.6	463.1	19,070,555.6
4	Татварын өмнөх ашиг, алдагдал	129,697,500.0	-365,731,421.8	-282.0	-495,428,921.8
5	Цэвэр ашиг (алдагдал)	99,510,000.0	-366,833,839.6	-368.6	-466,343,839.6
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	19,200,000.0	0.0	0.0	-19,200,000.0
7	Нийт ажиллагсдын тоо	158.0	158.0	100.0	0.0
8	Нийт цалингийн сан	1,802,438,200.0	1,874,259,234.0	104.0	71,821,034.0
9	Нэг ажилтны дундаж цалин	950,653.1	988,533.4	104.0	37,880.3
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.1	112.6	0.1
11	Нийт хөрөнгө оруулалт	646,283,000.0	898,810,280.1	139.1	252,527,280.1
12	Нийт авлага	950,000,000.0	1,041,106,937.9	109.6	91,106,937.9
13	Өглөг:	1,220,000,000.0	1,276,194,172.5	104.6	56,194,172.5
	- Богино хугацаат өр	920,000,000.0	1,276,194,172.5	138.7	356,194,172.5
	- Урт хугацаат өр төлбөр	300,000,000.0	0.0	0.0	-300,000,000.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019-12-31	Аудитын нэр: Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код: САГ-2020/18/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Геологийн төв лаборатори ТӨҮГ	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2018 оны жилийн эцсээр 341 харилцагчын 397.3 сая төгрөгийн авлага байсан нь тайланд онд барагдаагүй, өмнөх жилийн үлдэгдлээс өөрчлөгдөөгүй тооцоо нийлсэн акт бичиг баримт байхгүй байна.	397.3	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Э.Тэгшжаргал М.Хоролсүрэн
2	Найдваргүй авлагын нөөц байгуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн	-	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Э.Тэгшжаргал М.Хоролсүрэн
	Нийт	397.3			